



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/558

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дүгээр хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр зарлиг, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Намрын мод тарих ажлын хүрээнд Есөнбулаг сумд тарих модны нүх ухах шатахууны зардалд 2.600.000 (хоёр сая зургаан зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардлыг Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 108 сая мод тарьж ургуулах арга хэмжээний хөтөлбөрөөс санхүүжүүлж, Сум дундын ойн ангид шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Ажлыг чанартай гүйцэтгэж, тайлагнахыг Сум дундын ойн анги (А.Баасандаш)-д үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

